

50 ЖИЛИЙН ӨМНӨ ЧЕХҮҮД ЭРДЭНЭТИЙГ НЭЭСЭН ТУХАЙ

Монгол Улс сүүлийн жилүүдэд эдийн засгийн өсөлтөөрөө толгой цохиж газар доорх баялаг руу нь гадны хөрөнгө оруулагчид уралдан өрсөлдөж байгаа билээ. Харин 2013 оны 10-р сарын 28-ны тэмдэглэлт өдөр Монголын төр анх зах зээлд хөл тавих үед нь тус болж байсан гадаадын иргэдийг үл мартан төрийн дээд шагнал болох „Алтан гадас” одонгоор энгэрийг нь мялаасан байна. Дэлхийн хэмжээний зэсийн орд болох Эрдэнэтийн овоог анх нээсэн Чехийн геологийн экспедицийн ахлагч, энэ түүхэн үйл явдлын сүүлийн гэрчүүдийн нэг геологич Моймир Краутер нь 50 жилийн дараа ийнхүү гавьяагаа үнэлүүлсэн байна.

Энэ тухай МОНЦАМЭ-гийн цахим хуудсанд гарсан даруухан мэдээ нь олон арван жилээр үнэнийг нуун дарагдуулж байсан явдалд цэг тавьсан гэлтэй.

Олон арван жилийн туршид Монгол Улсын санг тэтгэж байсан

энэ амин чухал ордыг чухам Чехүүд / тэр үед Чехословакууд/ анх нээснийг Улс төрийн шалтгааны улмаас нуусаар иржээ. Их баялгийн эзэд болохоо мэдээгүй байх үеийнхээ жинхэнэ андуудаа хөгжин дэвжих үедээ мартаагүй явдал нь өнөөдрийн Монголын төрийн зүгээс хүндэтгэлийг хүлээсэн алхам байлаа.

Алдар гавьяанд хүрсэн хүн залуу үеийнхээ найз нөхдөө хэрэг болохгүй гэж мартаж нь олонтаа. Харин төлөвшиж, ухаан суусан хүн л чухам амжилтынхаа оргил үедээ тэдэнд гараагаа эхлэхэд нь тусалж байсан нөхдөдөө талархаж чаддаг билээ.

Монгол Улс хуучин Чехословак Улс хоёрын геологийн салбар дахь хамтын ажиллагаа 1957 оноос эхлэлтэй. Тэр үед Чехийн геологчдийн баг Монголын говийн нутаг, зүүн болон хойд нутгуудад байрлах орд газруудад очиж үзсэн байна. Үүний үр дүнд ашигт малтмалын хайгуул, олборлолтын чиглэлээр



БНЧУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Элчин сайд Ивана Гроллова

Монголын хойд нутагт хийгдсэн геологийн ажлуудын талаар хүүрнэхээс гадна төгсгөлд нь нэгэн малчны ирээдүйг зөгнөсөн гэмээр үгснийг сонсох боломжтой. Тэрээр “Эрдэнэтийн овоог ч яахав, харин урд зүгт, говийн нутагт үүнээс ч илүү баялаг байгаа. Тэнд оюут уул бий - Оюу толгой.” гэж хэлдэг.

